


Living the LOTUS

Buddhism in Everyday Life



1
2018

VOL. 148



Үүсгэн байгуулагчийн сургаал



Бурхантай холбогдох үйл

Өвлийн номын уншлага эхэлж, ид өвлийн тэсгим хүйтэнд гэгээ ч ороогүй байхад өглөө болгон нийгэмлэгт ирж, хичээнгүйлэн судар унших гишүүдийн дүр зураг харагдана.

Өвлийн уншлага дуусмагц биеийн эд эс бүхэлдээ ариуссан мэт мэдрэмж төрдөг. Бурхантай холбогдоход ийм цэвэр ариун мэдрэмж чухал байдаг.

20-р зууны сүүлийн 10 жилийг угтаад байгаа өнөө үед бид хэрхэн залбирч, ямар үйл хөдлөл хийхээс шалтгаалж 21-р зуун ямар болох нь шийдэгдэнэ. Дэлхий нийгэмд тулгараад байгаа

асуудал хичнээн том харагдаж байгаа ч гэсэн хүн бүр дор бүрнээ өөрийгөө өөрчлөх үйл хийхээс эхлэх хэрэгтэй. Ингэснээр ямар нэгэн арга зам заавал гарч ирнэ.

Хүсэл шунал, хувийн үзэл бодолдоо автагдах гээд байдаг өөрийгөө засах үйл хийж, Бурханы билиг оюуныг мэдрэх юмсан хэмээн үнэн сэтгэлээсээ залбирах хүмүүсийн тоог нэг нэгээр нэмэх нь одоо бидний хийх хамгийн чухал үйл юм. Өвлийн номын уншлагаар дамжуулж ийнхүү сэтгэлээ засаж, шинэ хүн болохыг хүсэж байна.

Living the Lotus
Vol. 148 (2018.01)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Кооичироо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК


Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганума Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулъя гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Ерөнхийлөгчийн сургаал

Өөдрөг, гэгээлэг амьдрах



Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Өөрөө зул мэт байх



Жилийн эхний өдөр гэсэн ханзыг бичихдээ хөндлөн зураас дээр нар гэсэн ханз бичдэг. Энэ нь тэнгэр газрын заагаас нар мандаж байгааг дүрсэлсэн утгатай. Шинэ жилийн анхны нарны цэвэр тунгалаг гялбааг харах үед бие сэтгэл сэргэн шинэ оныг угтдаг.

Ийнхүү шинэ жилийг угтахдаа та бүхэн ямар жил байгаасай гэж хүсдэг вэ?

Хүн бүрийн бодол өөр байж магадгүй ч гэрэл гэгээтэй, өөдрөг сайхан байгаасай гэж хүн бүр хүсдэг болов уу.

Хэрэв тийм бол ингэж амьдрахын тулд бидэнд амьдрах энергийг өгдөг нар шиг эхлээд өөрөө гэгээлэг, өөдрөг байж, хүмүүсийг тайвшруулж, баярлуулахыг мартаж болохгүй. Хааяа хүнээс дэмжлэг туслалцаа авч, бусад хүний өөдрөг гэгээлэг байдлаас эрч хүчийг мэдрэх үе байж болох ч, өөрөө өөдрөг гэгээлэг амьдрах хамгийн чухал.

Гэхдээ “төрөлхийн тийм зан байхгүй болохоор хэцүү” хэмээн бууж өгөн, санаа алдах хүн байдаг бололтой. Гэвч бууж өгч болохгүй.

Бурханы сургаалд “өөрөө зул мэт байж, сургаалыг зул мэт сэтгэ” хэмээх сургаал байдаг.

Өөрөө зул мэт байх гэдэг нь “аливаа үзэгдэлд автагдахгүй, амьдралд хандах өөрийн гэсэн чин итгэл үнэмшилтэй байх”-ыг хэлнэ. Зул нь зулын гол, тос хоёр байж байж бадамлан асдаг. Зулын гол нь хүмүүс юугаар ч солишгүй нандин амь насыг олж, яг одоо, энд амьдарч байна гэсэн чин итгэл үнэмшил юм. Харин итгэл үнэмшлийг улам бадрааж байдаг “зулан тос” нь одоо байгаа зүйлдээ “талархах сэтгэл” гэж хэлж болно.

Сургаал номд тулгуурлах

Буддын Зэн урсгалын “хөлгүй хувраг” хэмээн алдаршсан ламтан байдаг. 1945 онд Солонгосын хойгт дайн дуусч, 25 настай байсан тэрээр Сибирийн олзлогсдын лагерь руу хүргэгдэн, хоёр хөлөө хөлдөөснөөс болж өвдөгнөөс дооших хэсгээ тайруулжээ. 26 настайдаа Японд буцаж ирсэн хэдий ч, тийм биетэйгээр буцах ирэхийн тулд, буцаж ирснээсээ хойш ямар их зовлон бэрхшээл туулсныг төсөөлөхийн аргагүй. Гэтэл тэрээр 27 насандаа “гэгээрэлтэй төстэй зүйл”-ийг мэдэрсэн гэдэг. Тэр нь “хүн өөрийгөө бусадтай харицуулдаг болохоор л зовдог юм байна” хэмээх ухаарал байжээ. Энэ хүн бол Озава Дооюү ламтан байсан юм.

“Харьцуулах сэтгэлийн үндэс 27 жилийн өмнө төрөхөд бий болсон юм бол 27 жилийн өмнө төрснөө мартаж, өнөөдөр хоёр хөлөө тайруулсан чигээрээ дахин төрөх юм бол тэр сэтгэл ч байхгүй болно. Шинээр мэндэлсэн хүний хувьд бүх юм шинэ байдаг шүү дээ. Өнөөдөр, яг одоо би дахин төрж байна.”

Тэр өдрөөс хойш тэрээр “өнөөдөр, яг одоо би дахин төрж байна” хэмээх үгийг санаж, “үргэлж инээмсэглэн”, “заавал баярлалаа хэмээн талархаж”, бурханы зам мөрөөр алхсан гэдэг.

Гэгээлэг, өөдрөг амьдрахын тулд төрөлхийн өөдрөг зантай байсан байгаагүй гол нь юуг итгэл үнэмшилээ болгож, баримтлах вэ гэдэг чухал бөгөөд бурханы шавь бидний хувьд бурханы сургаалыг баримтлах чухал гэдгийг Озава ламтан сургасан гэж бодож байна. Сургаалыг зул мэт сэтгэж амьдрах гэдэг үүнийг хэлэх болов уу.

Нөгөөтэйгүүр зовлон бэрхшээлийн цаана жинхэнэ гэгээлэг, өөдрөг амьдрал байдаг гэж хэлж болно. Тэгвэл зовлон бэрхшээлийн цаана гарахын тулд сая хэлсэн “чин итгэл үнэмшил”-тэй байхаас гадна олон янзын бодолд автагдахгүй, сэтгэлээ нэг зүйлд төвлөрүүлэх чухал.

Японы *хаику* шүлгийн яруу найрагч Такахама Кёоши (1874–1959) “Шинэ жил гарч шинэ хүн боллоо. Одоо хийх л үлдлээ” хэмээх эрч хүчийг мэдрүүлэх шүлэг бичиж үлдээсэн байдаг. Энэ шүлэгт бичсэнчлэн “шинэ хүн боллоо” гэсэн сэтгэлээр энэ жилийг өөдрөг, гэгээлэг өнгөрөөцгөөе.

“Косей” сэтгүүл 1-р сарын дугаараас



The 7 Parables of the Lotus Sutra

Оройн Дээд Цагаан
Лянхуа Судар

Баян аав ба ядуу хүүгийн үлгэр

4-р бүлэг: Сүслэн авахуйг үгүүлэхүй

Баян айлд төрсөн нэгэн хүү байжээ. Хүү бага байхдаа гэрээсээ яваад олон жил өөр улсад ядуу зүдүү амьдарчээ. Ганц хүүгээ алдсан аав нь ихэд гашуудан улс даяар эрж хайсан боловч олдоогүй тул арга барагдан тансаг орд харшдаа зарц нартайгаа амьдарч байжээ. Хүү нь энд тэндгүй тэнүүчлэн явсаар 50 настайдаа төрсөн нутагтаа эргэн ирэв. Нэгэн өдөр аавынхаа гэр гэдгийг ч мэдэлгүй том орд харшийн өмнө явж очжээ. Гайхалтай тансаг орд харшийг хашааны завсраар шагайн хараад “энд байгаад байх юм бол баригдаж магадгүй” хэмээн айгаад зугтав.



Аав нь хүүгээ өдөр болгон боддог байсан тул ордон дотроос хүүгээ хараад шууд л танив. Хүү нь гэнэт зугтахыг хараад гайхан, тэр хүнийг дагуулаад ир хэмээн зарцдаа хэлэв. Зарц хүүг бариад автал хүү нь айсандаа ухаан алдаад уначихав.

Аав нь хүүгээ хүчээр авчрахаа больж, дараа нь ноорхой хувцастай хоёр зарцаа явуулж ордонд ариун цэврийн өрөө цэвэрлэх ажил хийхийг санал болгов. Хүү өөртэйгөө ижил хүмүүсийг хараад сэтгэл нь тайвширч, ажиллахаар болов. Аав нь өөрөө хүртэл хиртэй хуучин хувцас өмсөж, хүүтэйгээ хамт ажиллаж дотноссоор “би чамайг төрсөн хүү шигээ боддог юм шүү” гээд дотночилон нэр хүртэл хайрлав.

Түүнээс хойш 20 жил цэвэрлэгээ хийсэн хүү нь арай гэж гэртээ дасаж ирсэн боловч өөртөө итгэлгүй, сул дорой хэвээрэй л байв. Удалгүй аав нь өвдөж, насан эцэслэх дөхснөө мэдээд эрдэнэсийн агуулахаа хүүдээ хариуцуулах болов.

Хүү нь аавынхаа гэрийн эд баялагийг бүгдийг хариуцах болсноор бага багаар өөртөө итгэлтэй болж ирэв. Хүүгийнхээ сэтгэлийг анзаарсан аав нь насан эцэс болохынхоо өмнө олон түмнийг цуглуулан “үнэндээ энэ хүн бол миний төрсөн хүү юм. Миний эд хөрөнгө бүгд энэ хүүгийнх болно” хэмээн тунхаглав. Хүү “энэ их эд хөрөнгийг авах юмсан гэж бодож ч байгаагүй байтал одоо бүгд минийх боллоо гэж үү” хэмээн сэтгэл хөдлөн, маш ихээр баярлажээ.



Тайлбар:

Аав нь Бурхан, хүү нь бидний дүр төрх юм. Бид Бурханы ач ивээлээс зугтан, зовлонгийн дунд өөрөө явж ордог. Гэвч хэзээ нэгэн цагт “аяндаа” Бурхан руу дөхдөг байна. Яагаад гэвэл өөрөө анзаараагүй байсан ч гэсэн бидэнд бурханлаг чанар байдаг болохоор юм. Бурхан биднийг хараад үргэлж өөрийнхөө хүүхэд гэж боддог. Мөн үргэлж бидний төлөө бодож байдаг.

Бурхан биднийг аль болох хурдан гэгээрэлд хүргэхийг хүсдэг боловч хүмүүс бид “миний чадах зүйл биш байна” хэмээн гэдрэгээ харчихдаг байна. Тиймээс Бурхан биднийг тайвшруулах арга (уран арга) хэрэглэн үргэлж бидний дэргэд байдаг. Ариун цэврийн өрөө цэвэрлэх гэдэг нь үйлийн үрээс ангижирах бурханы үйл хийхийг илэрхийлсэн утгатай.

Хүү бүтэн 20 жил бурханы үйл хийсэн хирнээ өөртөө итгэлгүй хэвээрээ л байдаг. Бурхан “чи бол төрсөн үртэй минь адил тул хүүгээ хэмээн бодож нэр хайрлая” гэж хэлсэн ч гэсэн Бурханаас зайгаа барьсаар байдаг. Олон жил бурханы үйл хийснээр бурханы сургаалыг хүлээж авдаг болж, эрдэнэсийн агуулахыг хариуцах болдог ч гэсэн эрдэнэс бүгд өөрийнх нь гэж бодоогүй. Өөрөөр хэлбэл өөрт ч гэсэн эрдэнэ (бурханлаг чанар) байдгийг анзаардаггүй байна.

Сургаалыг хэрэгжүүлж, бага багаар өөртөө итгэлтэй болоод ирэхээр Бурхан “хамаг амьтан бол Бурханы үр хүүхэд юм. Бүх хүн бурханы гэгээрэлд хүрэх боломжтой” хэмээн сургаалаа айлддаг. Улмаар бид арай гэж Бурхантай нэгэн бүхэл болохоо ойлгодог байна.

Бид хэдийн Цагаан Лянхуа Судартай учирсан болохоор тойруу замаар явалгүй шууд л бурханы айлдварыг сонсож, бурхантай нэгэн бүхэл болох боломжтой. Үүний тулд эхлээд өөртөө итгэлгүй байдлаасаа гарах хэрэгтэй. Сэтгэлээ өөдрөг байлгаж, “би ч гэсэн бурханы гэгээрэлд хүрч чадна”, “би сансар огторгуйтай нэгэн бүхэл” гэж өөртөө хэлээд үзээрэй. Тэгээд сургаалд итгэж, хэрэгжүүлснээр өөртөө итгэх бат итгэл төрөх болно. Зовлон бэрхшээлтэй тулгарсан үедээ ноорхой хувцас өмсөн ядуу хүүтэй хамт цэвэрлэгээ хийх Бурханыг санаж байгаарай. Бурхан үргэлж бидний дэргэд байдаг юм шүү.

Чююо эрдэм шинжилгээний институт





Хором бүрийг чухалчлах


Та бүхэнд шинэ жилийн мэнд хүргье.

Энэ жил ч гэсэн тусалж дэмжиж байгаарай.

Шинэ жил болохоор сэтгэл хүртэл шинэчлэгдэн сэргэдэг нь гайхалтай. Өмнөх жилтэй ганцхан хоногийн ялгаатай байхад яагаад ийм мэдрэмж төрдөг юм бол? Гэхдээ ийм онцгой мөч чухал ч байж магадгүй.

Нивано ерөнхийлөгч «Сэтгэлээ хөгжүүлэх» номондоо “Хором мөч бүр цоо шинэ, өдөр бүр амьдралын анхны өдөр байдаг. Өнөөдөр гэдэг өдөр өнгөрсөнд ч, ирээдүйд ч байхгүй хамгийн гайхалтай өдөр юм” хэмээн бичсэн байдаг. Өнөөдрийн би амьдралд ганц л тохиолдоно. Хэн нэгэнтэй учирсан тэр учрал ч гэсэн анхны бөгөөд сүүлийнх байдаг. Тиймээс шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан үргэлж “одоо”-г чухалчилж, учрал бүрт чин сэтгэлээсээ хандаж, энэ жилийг гэгээлэг, өөдрөг өнгөрүүлцгээе!

Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Кооичи



❀ RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES ❀



We welcome comments on our newsletter *Living the Lotus*: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2018

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437
e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA
Tel: 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-6437
e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com
<http://home.earthlink.net/~rkchi/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Taichung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai